

# **ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

---

Улаанбаатар хот  
2021 он

## **ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

### **НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын цэргийн хээрийн сургууль, дадлагад оролцох гадаад орны цэргийн багийн зэвсэглэл, цэргийн техник бусад эд материалыг хилээр нэвтрүүлэхэд Гаалийн тухай хуульд заасан тодорхой мөнгөн дүнг төрийн сангийн тусгай санд байршуулахгүйгээр, мөн батлан хамгаалах зориулалтаар олон улсын тусламж, худалдааны гэрзэгээр, импортоор оруулж ирж байгаа барааг гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийдэг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ шаардлагаас урган гарч байна.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хууль нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэртэй байна.

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”<sup>1</sup>-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шаттайгаар хийлзээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

### **ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төсөлд туссан зохицуулалт болон арга хэмжээнүүд нь хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэх боломжтой байдлаар томьёологдсон эсэхийг үнэллээ.

Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тооцож үзсэн.

<sup>1</sup>Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь төрийн байгууллагад учрах зардлыг бууруулах боломжийг бий болгох ба субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

## **ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, холбогдох зохицуулалтууд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуультай нийцүүлэн боловсруулсан ба дагалдан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

### **Эрх зүйн зохицуулалт:**

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 4.5-д “Монгол Улсын батлан хамгаалах нөөцийн менежмент, түүнд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, батлан хамгаалах зориулалт бүхий материаллаг нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх тогтолцоог төгөлдөржүүлнэ” гэж, 8.2.5-д “байлдааны зэвсэг, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх” гэж, Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.2.5-д “зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх” гэж, Батлан хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино” гэж, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах нь төрийн үүрэг мөн. Төр нь улсыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлнэ” гэж тус тус заажээ.

### **Практик хэрэгжилтийн байдал:**

Практик үндэслэл, шаардлагын хувьд өнеөдрийн байдлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь цэргийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн 36 улстай цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаатай ажиллаж байна. Үүнээс ОХУ, БНХАУ, БНТУ, Украян Улс, Белерусь

Улстай цэрэг-техникийн салбарт, АНУ, ХБНГУ, БНСУ, Израйль Улс, ИБУИНВУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулан Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, хэрэгслийг сольж шинэчлэх, энхийг дэмжих ажиллагааны оролцох чадавхыг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдыг сургаж, бэлтгэх, хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Иймд Гаалийн тухай хуулийн зохицуулалтад Монгол Улсад явагдах олон улсын чанартай цэргийн хээрийн сургууль, дадлагад оролцох гадаад улсын орны цэргийн баг бүрэлдэхүүний зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулах эрх зүйн зохицуулалтад холбогдох өөрчлөлтийг оруулан зохицуулалт хийх хэрэгцээ шаардлага байна гэж үзлээ.

Иймд улсын төсвөөс санхүүжилттэй батлан хамгаалах яам нь Гаалийн тухай хуульд заасан улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, төрийн сангийн тусгай дансанд байршуулахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтаар тодорхой мөнгөн хөрөнгийг байршуулах хөрөнгийн эх үүсвэргүй хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байдагтай холбогдуулан Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар асуудлыг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

Дээр дурдсан хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2-т заасны дагуу Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Аливаа хуулийн зохицуулалт нь Үндсэн хууль болон хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас хамгийн эхэнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага /Үндсэн зорилго, дэд зорилго/ хуулийн төслийн үзэл баримтлалаас	Хуулийн төслийн зорилго
<p>Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын цэргийн хээрийн сургууль, дадлагад оролцох гадаад орны цэргийн багийн зэвсэглэл, цэргийн техник бусад эд материалыг хилээр нэвтрүүлэхэд Гаалийн тухай хуульд заасан тодорхой мөнгөн дүнг төрийн сангийн тусгай санд байршуулахгүйгээр, мөн батлан хамгаалах зориулалтаар олон улсын тусламж, худалдааны гэрээгээр, импортоор оруулж ирж байгаа барааг гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийдэг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын цэргийн хээрийн сургууль, дадлагад оролцох гадаад орны цэргийн багийн зэвсэглэл, цэргийн техник бусад эд материалыг хилээр нэвтрүүлэхэд Гаалийн тухай хуульд заасан тодорхой мөнгөн дүнг төрийн сангийн тусгай санд байршуулахгүй болох</li> <li>- Батлан хамгаалах зориулалтаар олон улсын тусламж, худалдааны гэрээгээр, импортоор оруулж ирж байгаа барааг гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийдэг болох эрх зүйн зохицуулалтыг бий болгох зохицуулалтыг тусгах.</li> </ul>

**“Практикт хэрэгжих боломж”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд шинээр тусгах зохицуулалтыг сонгож авлаа.

**“Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байдал, хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

**“Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

### **ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	<p><b>1 дүгээр зүйл.</b> Гаалийн тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:</p> <p>1/95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэг:          “95.3. Энэ хуулийн 95.1-д энхийг сахиулах болон олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар өөрийн оронд зохион байгуулах цэргийн хээрийн сургууль, дадлагад зориулан хилээр нэвтрүүлэх бараа хамаарахгүй”</p> <p>2/29 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дахь заалт:          “29.1.8. Батлан хамгаалах зориулалтаар буцалтгүй тусlamж болон худалдааны гэрээгээр нийлүүлэгдсэн бараа”</p>	Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
		<p><b>2 дугаар зүйл.</b> Гаалийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтын дугаарыг “29.1.9” гэж өөрчилсүгэй.</p>	Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
		<p><b>3 дугаар зүйл.</b> Энэ хуулийг 2022 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	Хуулийн төслийн зохицуулалтад дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг судлах

3	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

**“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**  
Хуулийн төслийг түүний үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байдалтай харьцуулан үзэж, холбогдох зохицуулалтын эрх зүйн үр дагаврыг тодорхойлоход чиглэсэн.

**Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл.**

**1 дүгээр зүйл.** Гаалийн тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэг:

“95.3. Энэ хуулийн 95.1-д энхийг сахиулах болон олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар өөрийн оронд зохион байгуулах цэргийн хээрийн сургууль, дадлагад зориулан хилээр нэвтрүүлэх бараа хамаарахгүй”

**2/29 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дахь заалт:**

“29.1.8. Батлан хамгаалах зориулалтаар буцалтгүй тусlamж болон худалдааны гэрээгээр нийлүүлэгдсэн бараа”

Гаалийн тухай хуульд Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын цэргийн хээрийн сургууль, дадлагад оролцох гадаад орны цэргийн багийн зэвсэглэл, цэргийн техник бусад эд материалыг хилээр нэвтрүүлэхэд Гаалийн тухай хуульд заасан тодорхой мөнгөн дүнг төрийн сангийн тусгай санд байршуулахгүйгээр, мөн батлан хамгаалах зориулалтаар олон улсын тусlamж, худалдааны гэрээгээр, импортоор оруулж ирж байгаа барааг гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлт хийхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалт тодорхой болно гэж үзсэн.

**Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл.**

**2 дугаар зүйл.** Гаалийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтын дугаарыг “29.1.9” гэж өөрчилсүгэй.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалтын дугаарыг “29.1.9” гэж өөрчилж, хуулийн дэс дараалал ойлгожмтой болно.

**Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл.**

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс

эхлэн дагаж мөрдөнө.

Хууль батлагдснаар хуулийн хүчин төгөлдөр мөрдөх хугацаа тодорхой болно.

**“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах заалтад заасан шаардлагыг хангасан эсэхэд хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан.
29.1.2. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тийм.
29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгаагүй.
29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох саналыг тусгаагүй.
29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.

29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зэрчсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байхгүй болно.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлага хангасан.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

**“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах”шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зориллоо.

Д/Д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Шаардлага хангасан.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардаагүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Шаардлага хангасан.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуульд шаардлагатай зохицуулалтыг бүрэн тусгасан.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төсөлд төрийн чиг үүргийг давхардуулан хуульчлаагүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Шаардлага хангасан.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Татвар хураамж тогтоосон заалт байхгүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт	Хуулийн төсөл нь жендерийн эрх тэгш

	жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	байдлын асуудлыг хөндөөгүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлд хариуцлагын хэм хэмжээтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй.

## ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

### 5.1.Баримтжуулалт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайландаа баримтжуулж хавсаргалаа.

1. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээг шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан;
2. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, түүнд нийцүүлж боловсруулсан хуулийн төслийн хувилбар;

### 5.2. Үнэлэлт дүгнэлт

Энэхүү үнэлгээний ажлын явцад Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан тогтоохдоо холбогдох байгууллагуудын саналыг авах, холбогдох мэргэжлийн алба хаагчдын оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид харьцуулан дүн шинжилгээ хийх зэрэг аргыг ашигласан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

#### Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Эх орныхоо тусгаар тогтолцыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэж заасан суурь зохицуулалт хангаждаж, батлан хамгаалах салбарт гадны тусламж, дэмжлэгээр оруулж ирж байгаа буцалтгүй тусламжийн бараа болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан цэргийн зэвсэглэл, бусад бараа материалыг хил, гаалийн нэвтрүүлэхтэй холбогдсон хуулийн зохицуулалт боловсронгуй болж, гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах барааны мөнгөн дүнтэй холбогдох асуудал шийдвэрлэгдэх ач холбогдолтой. Ингэснээр улсын төсвөөс ямар нэгэн нэмэлт зардал гарахгүй, хэмнэлт үүсэх юм.

#### Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Түүнчлэн хуулийн төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад

тавих нийтлэг шаардлага хангасан эсэх, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судаллаа.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан гэж үзлээ.

**Зардал гэсэн шалгуур үзүүлэлтээр:**

Зардал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу холбогдох зардлыг тодорхой тооцсон тул энэхүү үнэлгээний тайландаа дүгнэлтийг тусгаагүй болно.

**Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхийг зорьж, Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгалаа.

### **5.3. Зөвлөмж**

Монгол Улсын Үндсэн хуулийн арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заасан суурь зохицуулалт хангагдаж, батлан хамгаалах салбарт гадны тусlamж, дэмжлэгээр оруулж ирж байгаа буцалтгүй тусlamжийн бараа болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан цэргийн зэвсэглэл, бусад бараа материалыг хил, гаалийн нэвтрүүлэхтэй холбогдсон хуулийн зохицуулалт боловсронгуй болж, гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд байршуулах барааны мөнгөн дүнтэй холбогдох асуудал хууль зүйн хүрээнд шийдвэрлэгдэж, улс орныг батлан хамгаалах чадавхи эрс сайжирна гэж үзэж байна.

---Оо---